



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2024/08/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Дундговь аймаг 2024 он	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Ихбаяр Утас: 70593113 Цахим хаяг: ikhbayard@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

.....	0
1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /мянган төгрөгөөр/	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /мянган төгрөгөөр/	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөгөөр/	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөгөөр/.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөгөөр/	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөгөөр/.....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	6
3.1.2 Албан шаардлага.....	7
3.1.1 Зөвлөмж.....	7
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СХС	Сум хөгжүүлэх сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БХС	Байгаль хамгаалах сан
МХС	Мал хамгаадах сан
ОННТ	Орон нутгийн нэгтгэсэн тайлан

1.Аудитын санал дүгнэлт



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРЦОГТ
СУМЫН ЗАСАГ ДАРГА М.БАЯРСҮХ
ТАНАА

2024-03-25 № 125
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 839.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч, 28,643.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан байна. Үндсэн хөрөнгийн данс 662,442.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь сумын 100 жилийн баяр наадмын хүрээнд хандив тусламж бусад эх үүсвэрээр ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд үнэ төлбөргүй ирсэн үндсэн хөрөнгийн өсөлттэй холбоотой байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Засаг даргын Тамгын газар нь жилийн эцсийн хөрөнгийн тооллогын явцад хяналт тавиагүй, тооцоог бодож баталгаажуулаагүй, тооллогын бүртгэлээрх хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд дахь хөрөнгийн үлдэгдлээс зөрүүтэй тайлагнасан,

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, сумын 2023 оны татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 129.5 хувиар буюу 77.6 сая төгрөгөөр, орлогын төрлөөрөө 7 нэр төрлийн орлого 10.4 сая төгрөгөөр тасарсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, Орон нутгийн хөгжлийн санд малын тоо, толгойн албан татварын орлогоос төвлөрүүлэх санхүүжилтийг 4.5 сая төгрөгөөр илүү тооцож олгосон зэрэг зөрчил нь тайлант үеийн өндөр үнэлэгдсэн эрсдэлтэй асуудал байлаа.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 30 зорилт, 93 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 90.2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	524,285.80	663,958.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	226,706.10	240,968.20
33	АВЛАГА	116,487.10	196,165.30
35	БАРАА МАТЕРИАЛ	125,742.60	171,475.30
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	55,350.00	55,350.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,486,192.40	3,148,635.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,486,192.40	3,148,635.00
39200	Биет хөрөнгө	2,451,039.80	3,108,165.10
39300	Биет бус хөрөнгө	35,152.70	40,469.90
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,010,478.30	3,812,593.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	681.1	774.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	681.1	774.8
41300	Өглөг	681.1	774.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,009,797.20	3,811,819.00
51	Засгийн газрын хувь оролцоо	3,009,797.20	3,811,819.00
51100	Засгийн газрын оруулсан капитал	613,064.80	613,064.80
51200	Хуримтлагдсан үр дүн	799,798.20	1,601,820.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,596,934.10	1,596,934.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,010,478.30	3,812,593.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,633,902.90	2,043,740.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО	196,269.80	281,527.30
110	Орлогын албан татвар	118,048.70	143,914.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	118,048.70	143,914.20
113	Хөрөнгийн албан татвар	61,572.00	66,498.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж	16,649.10	71,114.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	419,369.50	989,382.10
120	Нийтлэг татварын бус орлого	419,369.50	989,382.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,018,263.60	772,831.40
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,301,919.10	1,003,685.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,301,919.10	1,003,685.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	633,060.80	808,204.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,635.20	340,724.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,760.40	42,346.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,443.60	48,154.70
2104	Хангамж, бараа материалын зардал	79,491.90	82,821.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,921.40	15,975.90
2107	Томилолт, зочны зардал	9,554.00	13,965.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,353.80	18,783.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	197,900.60	245,432.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	668,858.30	195,481.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	331,983.80	1,040,055.50
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	806.3	1,808.50
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,128,546.90	226,879.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,795,756.90	814,985.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,022,305.5	5,022,305.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-216,751.4	-216,751.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,805,554.0	4,805,554.0
9	Тайлант үеийн үр дүн	-1,795,756.9	-1,795,756.9
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,009,797.2	3,009,797.2
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,009,797.2	3,009,797.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-12,963.2	-12,963.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,996,834.0	2,996,834.0
19	Тайлант үеийн үр дүн	814,985.0	814,985.0
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	3,811,819.0	3,811,819.0

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,508,695.60	1,205,722.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	196,269.80	281,527.30
110	Орлогын албан татвар	118,048.70	143,914.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	118,048.70	143,914.20
113	Хөрөнгийн албан татвар	61,572.00	66,498.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж	16,649.10	71,114.40
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,575.00	14,460.40
1181	Газрын төлбөр	10,074.00	14,894.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0	41,760.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	134,512.80	182,729.00
120	Нийтлэг татварын бус орлого	134,512.80	182,729.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,177,913.00	741,465.80
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,300,278.90	813,106.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,300,278.90	813,106.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	623,579.20	790,873.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	272,385.10	340,887.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,332.70	41,857.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	150,063.40	49,926.20
2104	Хангамж, бараа материалын зардал	29,356.70	42,260.40
2105	Нормативт зардал	0	670.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,511.30	25,807.30
2107	Томилолт, зочны зардал	9,554.00	13,965.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,301.60	160,177.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,074.40	115,322.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	676,699.80	22,233.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	208,416.70	392,615.50
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	170,733.20	237,153.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	170,733.20	237,153.40
2200	Дотоод эх үүсвэрээр	170,733.20	237,153.40
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-170,733.20	-237,153.40
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0	-141,200.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0	141,200.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	37,683.50	14,262.10
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	189,022.60	226,706.10
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	226,706.10	240,968.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,227,479.90	1,153,300.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	827,640.90	784,546.7
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	814,076.9	771,182.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	348,966.6	340,887.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,989.0	41,857.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	209,392.6	177,845.6
2104	Хангамж, бараа материалын зардал	37,035.9	37,031.4
2105	Нормативт зардал	670.0	670.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,239.9	46,136.4
2107	Томилолт, зочны зардал	12,938.0	12,884.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,543.9	7,687.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,301.0	106,182.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,564.0	13,364.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,564.0	13,364.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	248,339.0	227,553.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	151,500.0	141,200.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,227,479.9	1,073,242.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	160,669.4	160,669.4
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	833,726.1	791,709.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	233,084.4	120,863.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	177,186.8
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	97,128.7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	35,275.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	35,275.7
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,704.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,195.9
2104	Хангамж, бараа материалын зардал	5,229.0
2105	Нормативт зардал	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	438.2
2107	Томилолт, зочны зардал	1,080.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,270.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,490.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,571.7
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,571.7
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	35,275.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,275.5
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-0.1
	Мөнгө түүнтэй ажилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.1

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитаар Аудитаар **14,878.1** мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлж **10,382.0** зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага, татварын орлогын бүрдүүлэлт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд **4,496.1** мянган төгрөгийн 2 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Залруулагдаагүй алдаа:

Аудитаар **14,878.1** мянган төгрөгийн зөрчил² илрүүлж **10,382.0** зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага, татварын орлогын бүрдүүлэлт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд **4,496.1** мянган төгрөгийн 2 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

3.1.2 Албан шаардлага

- Орон нутгийн хөгжлийн санд малын тоо, толгойн албан татварын орлогоос төвлөрүүлэх санхүүжилтийг **4,496.1** мянган төгрөгөөр илүү тооцож олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5-д /сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх;/, Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16-д /төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох;/, 14.2.2-т /өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох;/, 60.2-т /Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:/ 60.2.8-д /малын тоо толгойн албан татварын орлого./ заасныг тус тус зөрчсөн;

3.1.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг харуулав. Үүнд:

1. Татварын орлогын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: 2023 оны татварын орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр 129.5 хувиар буюу 77,633.6 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч 7 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 10,382.0 мянган төгрөгөөр дутуу биелүүлж, татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөний жигд биелэлтийг хангах ажлыг хангалтгүй хэрэгжүүлсэн.

Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.19. -д /нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах;/, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3.-т /санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;/, 41 дүгээр зүйлийн 41.2.-т /Бүх шатны төсөв захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ/, 41.2.1.-т /Хуулийн дагуу, улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухай төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/, Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.30.-д /"татварын улсын байцаагч" гэж энэ хуулийн дагуу татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлж, татвар төлөгчид үйлчлэх, татвар хураах, тайлан хүлээн авах, хяналт шалгалт хийх чиг үүрэг бүхий татварын албанд ажилладаг, эрх олгогдсон төрийн захиргааны албан хаагчийг;/ заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

- Татварын болон татварын бус орлогыг төлөвлөхдөө тайлант оны онцлог, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт, өмнөх оны гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, орлогын нэр төрлийг бүрэн төвлөрүүлэх.
- Сумын татварын алба буюу татварын байцаагч, татварын орлого бүрдүүлэлтэд хамаарах алба хаагч нарыг удирдлагаар хангаж, ажлын хариуцлагыг нь сайжруулж нэмэгдүүлж хууль тогтоомжид заасан эрх, үүргээ хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2024 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой холбоотой асуудал

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудаст төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой 191.6 сая төгрөгийн 14 шийдвэрийг мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 90.0 хувьтай байгаа тул шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх ерөнхий чиглэлийн дагуу зөвлөмж хүргүүлж байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн /Шилэн дансны зарчим/ 4.1.1-д /мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;/, 6.4.8-д /бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;/, 7.2 -т /Энэ хуулийн 7.1-д заасан эрх бүхий албан тушаалтан мэдээлэх үүргээ бусдад шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй./ заасныг тус тус зөрчсөн;

Өгсөн зөвлөмж:

- 2024 оны эхний 1-3 сард байршуулаагүй төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах холбоотой засаг даргын захирамж бусад мэдээллийг нөхөж байршуулж цаашид Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах;
- Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмын хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2024 оны 04 дүгээр сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шүүд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	НИЙТ	6	1	5		1			

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 178,863.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 38,793.5 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 1,926.7 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 138,142.8 мянган төгрөгийн 6 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 78.8 хувийг залруулагдаагүй, 21.7 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн үндэслэл

Тайлбар: Төсөвт байгууллага, тусгай зориулалтын сангуудын 2023 санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар ИТХ-д хүргүүлсэн **2,531.6** мянган төгрөгийн 1 албан шаардлага, ЗДТГ-т хүргүүлсэн **9,600.0** мянган төгрөгийн 1 албан шаардлага, Хоршоо хөгжүүлэх санд хүргүүлсэн **1,763.0** мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, Орон нутгийн хөгжлийн санд хүргүүлсэн **116,270.2** мянган төгрөгийн 1 албан шаардлага, Засаг даргад хүргүүлсэн **10,382.0** мянган төгрөгийн 1 зөвлөмж буюу нийт **140,547.0** мянган төгрөгийн зөрчлийг нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хамруулан авч үзлээ. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх **14,400.6** мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс **654.6** мянган төгрөгөөр буюу **4.3 хувиар бага** байна.

Иймд Дэлгэрцогт сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дэлгэрцогт сумын ИТХ	1	489.2	1	489.2			1	489.2				
Дэлгэрцогт сумын ЗДТГ	1	354.3			1	354.3	1	354.3				
Дэлгэрцогт сумын МХС	1	37,950.0			1	37,950.0	1	37,950.0				
Дүн	3	38,793.5	1	489.2	2	38,304.30	3	38,793.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Дэлгэрцогт сумын ИТХ	1	163.5	1	163.5								
Дэлгэрцогт сумын ЗДТГ	2	3,656.3			2	3,656.3						
Дэлгэрцогт сумын МХС	1	6,084.7			1	6084.7						
Дэлгэрцогт сумын ОННТ	1	4,496.10			1	4496.1						
Дүн	5	14,400.6	1	163.5	4	14,237.1	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дэлгэрцогт сумын ИТХ	1	2,531.6							1	2,531.6		
Дүн	1	2,531.6	-	-	-	-	-	-	1	2,531.6	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дэлгэрцогт сумын ЗДТГ	1	9,600.0			1	9,600.0						
Дэлгэрцогт сумын СХС	1	1,763.2			1	1,763.2						
Дэлгэрцогт сумын ОНХС	1	116,270.2			1	116,270.2						
Дэлгэрцогт сумын ОННТ	1	10,382.0					1	10,382.0				
Дүн	4	138,015.4	-	-	3	127,633.40	1	10,382	-	-	-	-
Нийт дүн	5	140,547.0	-	-	3	127,633.40	1.00	10,382.03	1.00	2,531.6	-	-